

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **Жоншны хүдэр нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012392

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **Жоншны хүдэр** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Шаардлагагүй.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Шаардлагагүй**

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:
2019 он

Тендерийн хамт 40 656 000 / дөчин сая зургаан зуун тавин зургаан мянга/ төгрөгийн дүн бүхий тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхтэй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 504 тоот өрөө, утас: 450060 + 152

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ